

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

"Гавшгай ус" ААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2026/028/НА-СТА-ОНӨҮГ**

<p>Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК Утас: 99052418 Цахим хаяг: V.Naranchimeg.POA@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**“ГАВШГАЙ УС” ААТҮГ-ЫН  
ДАРГА Б.ҮҮРДМӨНХ ТАНАА**

2026.03.15 № СЭА-2026/020/НА-СТА-ОНА-010045  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Гавшгай ус” ААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна


**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 20 дугаар зүйлийн 20.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, ТБОНӨХБАУХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтууд болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй,

- Шууд худалдан авах босго үнээс давсан шатахуун, нүүрсний нийт 88,600.5 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг нийтэд ил тод зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй,
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс насжилт өндөртэй авлага барагдуулах тодорхой үр дүнтэй ажил зөхийн байгуулаагүй.



### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

“Гавшгай ус” ААТҮГ нь тайлант онд аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 15,000.0 мянган төгрөгийн 14 дүгээр байрны халаалтын шугам засварын ажил, 87,000.0 мянган төгрөгийн “Д-насос хөдөлгүүр” ЭЦВ гүний насос, 164,183.7 мянган төгрөгийн цэвэр усны шугам татах ажил, 477,319.2 мянган төгрөгийн Дөмбөн хороололд шинээр цэвэр усны шугам татах ажил хийгдэж нийт 743,502.9 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэл тайланд тусгасан байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлант оны нийт орлогыг 1,740,317.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,609,755.9 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлээр 1,814,113.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,528,681.1 мянган төгрөгийн зардал гарган, 714,567.9 мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадаагүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Гавшгай-ус” ААТҮГ-ын 2025 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.


Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Б.БАТМӨНХ

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**



Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>6,848,884,700.24</b>	<b>7,225,655,371.43</b>
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>1,920,852,723.96</b>	<b>1,881,305,909.44</b>
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,065,043.02	6,384,384.89
1.1.2	Дансны авлага	1,682,639,226.11	1,693,460,244.31
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	100,000.00	100,000.00
1.1.6	Бараа материал	234,248,454.83	178,561,280.24
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,800,000.00	2,800,000.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,920,852,723.96</b>	<b>1,881,305,909.44</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,089,480,780.28	4,505,798,265.99
1.2.2	Биет бус хөрөнгө	838,551,196.00	838,551,196.00
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>4,928,031,976.28</b>	<b>5,344,349,461.99</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,848,884,700.24</b>	<b>7,225,655,371.43</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>6,848,884,700.24</b>	<b>7,225,655,371.43</b>
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>	<b>2,242,154,065.89</b>	<b>2,589,956,266.11</b>
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	2,242,154,065.89	2,589,956,266.11
2.1.1.1	Дансны өглөг	139,019,647.49	264,716,517.24
2.1.1.2	Цалингийн өглөг	61,831,149.38	67,116,359.76
2.1.1.3	Татварын өр	806,812,404.41	911,282,998.47
2.1.1.4	НДШ - ийн өглөг	1,232,539,664.61	1,344,889,190.64
2.1.1.5	Ногдол ашгийн өглөг	1,951,200.00	1,951,200.00
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,242,154,065.89</b>	<b>2,589,956,266.11</b>
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>2,242,154,065.89</b>	<b>2,589,956,266.11</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>4,606,730,634.35</b>	<b>4,635,699,105.32</b>
2.3.1	Өмч: - төрийн	294,374,941.69	294,374,941.69
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,026,649,071.80	5,026,649,071.80
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,088,387,300.00	2,831,890,286.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-2,802,680,679.14	-3,517,215,194.17
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	-2,802,680,679.14	-714,534,515.03
2.3.9	Өмнөх үеийн ашиг		
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>4,606,730,634.35</b>	<b>4,635,699,105.32</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,848,884,700.24</b>	<b>7,225,655,371.43</b>



## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31 9055436
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,873,643,444.55	1,783,029,416.36
2	Борлуулалтын өртөг	2,147,315,980.67	2,243,342,781.25
3	Нийт ашиг ( алдагдал)	-273,672,536.12	-460,313,364.89
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
8	Бусад орлого	2,466,811.65	31,083,841.24
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	163,766,067.55	257,416,153.30
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	43,372,483.01	27,888,838.08
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-478,344,275.03	-714,534,515.03
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-478,344,275.03	-714,534,515.03
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-478,344,275.03	-714,534,515.03
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-478,344,275.03	-714,534,515.03
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/


	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	294,374,941.69	5,026,649,071.80	1,556,423,439.00	2,324,336,404.11	4,553,111,048.38
3	Залруулсан үлдэгдэл	294,374,941.69	5,026,649,071.80	1,556,423,439.00	2,324,336,404.11	4,553,111,048.38
5	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0.00	0.00	0.00	-478,344,275.03	-478,344,275.03
6	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	531,963,861.00	0.00	531,963,861.00

9	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	294,374,941.69	5,026,649,071.80	2,088,387,300.00	2,802,680,679.14	4,606,730,634.35
11	Залруулсан үлдэгдэл	294,374,941.69	5,026,649,071.80	2,088,387,300.00	2,802,680,679.14	4,606,730,634.35
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-714,534,515.03	-714,534,515.03
14	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	743,502,986.00	0.00	743,502,986.00
17	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	294,374,941.69	5,026,649,071.80	2,831,890,286.00	3,517,215,194.17	4,635,699,105.32

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мерийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024оны 12-р сарын 31	2025оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,864,590,335.52	1,896,263,551.61
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,864,590,335.52	1,896,263,551.61
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,862,137,808.20	1,865,179,710.37
1.1.6	Бусад мөнгөн орлого	2,452,527.32	31,083,841.24
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,872,315,435.95	1,859,853,300.67
1.2.1	Ажиллагчдад төлсөн	780,366,155.75	926,082,876.23
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	133,916,220.00	145,833,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	320,497,110.56	247,978,419.79
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	357,959,135.84	274,720,987.18
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	141,501,389.93	142,777,833.31
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	4,000,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	114,026,994.82	101,431,281.02
1.2.9	Бусад мөнгөн зарлага	24,048,429.05	17,028,903.14
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-7,725,100.43	36,410,250.94
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	31,090,909.07
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	31,090,909.07



2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	31,090,909.075 9055436
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-7,725,100.43	5,319,341.87
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,790,143.45	1,065,043.02
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,065,043.02	6,384,384.89

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого /НӨАТ-гүй/	1,740,317,860.63	1,814,113,257.60	(73,795,396.97)	104.2
	Үйл ажиллагааны орлого	1,535,136,966.05	1,645,305,376.36	(110,168,410.31)	107.2
	Дулааны борлуулалт /Номгон/	183,632,053.33	137,724,040.00	45,908,013.33	75.0
	Бусад орлого	21,548,841.24	31,083,841.24	(9,535,000.00)	144.2
2	Нийт зарлагын дүн	2,589,755,897.83	2,510,656,128.45	79,099,769.38	96.9
3	Цалин хөлс	1,192,885,562.84	1,164,455,010.52	28,430,552.32	97.6
4	НДШ-ийн зардал	152,096,434.99	155,089,416.84	(2,992,981.85)	102.0
5	Бараа үйлчилгээний бусад зардал	1,244,773,900.00	1,191,111,701.09	53,662,198.91	95.7
	Цахилгаан	421,000,000.00	361,034,191.66	59,965,808.34	85.8
	Дулаан	35,423,900.00	36,960,731.05	(1,536,831.05)	104.3
	Нүүрс	68,853,000.00	51,639,844.14	17,213,155.86	75.0
	Түлш, шатахуун	37,678,000.00	42,005,447.08	(4,327,447.08)	111.5
	Засвар үйлчилгээний зардал	152,689,000.00	176,082,636.04	(23,393,636.04)	115.3
	Бичиг хэрэг	1,660,000.00	2,214,693.88	(554,693.88)	133.4
	Албан томилолт	5,280,000.00	6,660,000.00	(1,380,000.00)	126.1
	Хөдөлмөр хамгаалал, ариутгал халдаргүйжүүлэлт	14,000,000.00	16,391,412.93	(2,391,412.93)	117.1
	Ариутгал цэвэрлэгээ үйлчилгээний зардал	1,000,000.00	3,848,362.42	(2,848,362.42)	384.8
	Үндсэн хөрөнгийн элэгдэл	390,000,000.00	358,276,409.36	31,723,590.64	91.9
	Хангамжийн материалын элэгдлийн зардал	40,000,000.00	37,839,538.71	2,160,461.29	94.6
	Шуудан холбооны зардал	2,690,000.00	3,753,784.00	(1,063,784.00)	139.5

	Түрээсийн зардал	15,000,000.00	14,497,400.00	502,600.00	96.6
	Тээврийн зардал	6,000,000.00	5,658,350.00	341,650.00	94.3
	Сургалтын зардал	2,000,000.00	180,000.00	1,820,000.00	9.0
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	13,000,000.00	27,504,410.00	(14,504,410.00)	211.6
	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	2,500,000.00	8,447,412.45	(5,947,412.45)	337.9
	Хоол хүнсний зардал	7,000,000.00	6,672,250.00	327,750.00	95.3
	Цехийн тохижилтын зардал	13,000,000.00	13,073,727.30	(73,727.30)	100.6
	Бусад зардал	16,000,000.00	18,371,100.07	(2,371,100.07)	114.8
6	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	(849,438,037.20)	(696,542,870.85)	(152,895,166.35)	82.0
7	Орлогын албан татвар			-	
8	Үйл ажиллагааны бус зардал	20,000,000.00	18,025,000.00	1,975,000.00	90.1
	Үйл ажиллагааны бус бусад зардал	5,000,000.00	5,050,000.00	(50,000.00)	101.0
	Ажиллагсдын нийгмийн зардал	15,000,000.00	12,975,000.00	2,025,000.00	86.5
9	Татварын дараах ашиг, алдагдал	(869,438,037.20)	(714,567,870.85)	(154,870,166.35)	82.2
10	Хөрөнгө оруулалт	-	-	-	#DIV/0!

## 5. Аудитын илрүүлэлт :

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 745,625.4 мянган төгрөгийн дараах алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүн 714,534.5 мянган төгрөгийг хуримтлагдсан үр дүнгээр илэрхийлж тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авсан 31,090.9 мянган төгрөгийг “Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн” зардлаар бус бусад зардлаар тусгасан;

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд НББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандарт болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 846,044.2 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчил арилгуулах 3 албан шаардлага, 42,875.8 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 803,168.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 767,851.6 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1.Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс дараа зөрчил давтагдан гарсан байна. Үүнд:

- Тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр 714,567.9 мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй,
- 18-аас дээш жилийн насжилттай авлагыг барагдуулах үр дүнтэй ажил зохион байгуулаагүй,

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “ Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх

зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ..." 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах..." гэсэн заалтуудыг зөрчсөн гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.Өмнөх аудитаар өгсөн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчлийг давтан гаргасан, холбогдох албан тушаалтнууд албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх "...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, ...ыг хугацаанд нь биелүүлээгүй ..., санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэсэн заалтын дагуу ерөнхий нягтлан бодогч Д.Адъяасүрэн **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

### **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1.1.Илрүүлэлт:** Тус байгууллагын санхүүгийн тайлан дахь татвартай холбоотой өр төлбөрийн хэмжээ нь МТА-ны "Байгууллагын татварын тодорхойлолт"-оор НӨАТ-ын татвар 33,523.5 мянган төгрөгөөр, ХХОАТ 5,085.8 мянган төгрөгөөр, мөн ажилчдын цалингаас суутгасан ХХОАТ нь татварын тайлангаас 4,266.5 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах" гэсэн заалттай нийцэхгүй байна.


**1.2.Өгсөн зөвлөмж:** Татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, авлага, өр төлбөрийг үнэн зөв тайлагнах,

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.


## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл



/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг хуримтлагдсан үр дүнгээр илэрхийлж тайлагнасан	1	714,534.5			1	714,534.5	1	714,534.5				
Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авсан зардлыг "Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн" зардлаар бус бусад зардлаар тусгасан	1	31,090.9	1	31,090.9			1	31,090.9				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>745,625.4</b>	<b>1</b>	<b>31,090.9</b>	<b>1</b>	<b>714,534.5</b>	<b>2</b>	<b>745,625.4</b>				



**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй байна	1	714,567.9			1	714,567.9							
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс 18-аас дээш жилийн насжилттай авлагыг барагдуулах үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна	1	-			1	-							
Татвартай холбоотой өр төлбөрийг зөрүүтэй тайлагнасан.	1	42,875.8					1	42,875.8					
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>757,443.7</b>			<b>2</b>	<b>714,567.9</b>	<b>1</b>	<b>42,875.8</b>					

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	88,600.5			1	88,600.5				1	
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>88,600.5</b>			<b>1</b>	<b>88,600.5</b>				<b>1</b>	